



## МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БҮТЦИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ БОЛОМЖУУД

*Боловсруулсан: ВЭЗГ-ын ТТССХ-ийн эдийн засагч Б.Цэнгүүнжав<sup>1</sup>  
ВЭЗГ-ын ТТССХ-ийн эдийн засагч Б.Мөнхзул  
2015 оны 3 дугаар сар*

<sup>1</sup> Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн судлаачдын хувийн байр суурийг илэрхийлнэ. Судалгаатай холбоотой аливаа санал, зөвлөмж, шүүмжийг хүлээн авахдаа бид таатай байх болно. Мөн судалгааны ажилд хамтран ажилласан Аж үйлдвэрийн яамны ХҮБЗГ-ын мэргэжилтнүүдэд талархал илэрхийлье.

## ХУРААНГУЙ

Монгол Улсын эдийн засагт гадаад худалдаа чухал үүрэгтэй бөгөөд гадаад худалдааны уул уурхайн салбараас хараат байдал нэмэгдсээр байгаа учраас дотоодод үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний дэлхийн зах зээл, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвар, харьцангуй давуу тал, тухайн салбарт тулгамдаж буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэв. Гадаад худалдааны Херфиндал-Хиршманы индексээр Монгол Улсын экспорт цөөн төрлийн бүтээгдэхүүн, орноос хамаарал өндөртэй, харин импортын хувьд харьцангуй төрөлжсөн болох нь харагдсан. Түүнчлэн 2001-2013 оны хоорондох тоон мэдээлэлд суурилсан харьцангуй давуу талын шинжилгээний үр дүнд Монгол Улс уул уурхайн бус салбарт голчлон мал аж ахуйн бүтээгдэхүүнээр гадаад худалдаанд харьцангуй давуу талтай байна. Тэр дундаа ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн экспортын орлогоороо тэргүүлэх байр суурьтай байна. Уул уурхайн бус эдгээр бүтээгдэхүүний зах зээлийн судалгааны үр дүнд тус салбарт мэргэжлийн боловсон хүчний хомсдол, түүхий эд бэлтгэлийн доголдол, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн оновчтой логистикийн сүлжээ байхгүй зэргээс шалтгаалан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид бүрэн хүчин чадалдаа хүрч ажиллаж чадахгүй, борлуулалтын орлого дорвитой нэмэгдэхгүй байна. Тиймээс ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулахын тулд (i) анхан шат буюу түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, (ii) эцсийн болон завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч боловсруулах үйлдвэрүүдийн технологийг сайжруулах, (iii) үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд таниулан сурталчлахад дэмжлэг үзүүлэх, (iv) эдгээрт чиглэсэн тогтвортой санхүүжилтийн орчинг бий болгох шаардлагатай нь харагдлаа.

Эдийн засгийн бүтээлийн ангилал:

F13, O13, Q17

Түлхүүр үгс:

гадаад худалдааны төвлөрөл, худалдааны харьцангуй давуу тал, хөдөө аж ахуй

## УДИРТГАЛ

Гадаад худалдаа улам бүр нээлттэй болж буй өнөө үед улс орон бүр чөлөөт худалдааг эрхэмлэн гадаад худалдаанд оролцох хандлага давамгайлах боллоо. Гэвч хөгжиж буй орнуудын хувьд гол төлөв нэмүү өртөг бага шингэсэн, анхдагч түүхий эд эсвэл завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэх хандлагатай байна. Энэ нь эдгээр орны эдийн засаг дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнээс өндөр хамааралтай, хэлбэлзэл өндөртэй болох, эдийн засагт оролцогчдын хүлээлтээ зөв, оновчтой удирдах боломжийг хязгаарлах зэрэг эрсдэлийг бий болгодог.

Харин Монгол Улсын хувьд уул уурхайн салбараас хэт хамааралтай байгаа нь эдийн засаг тогтворгүй болох эрсдэл өндөр, гадаад үнээс хэт мэдрэмтгий байх үндсэн шалтгаан болж байна. Иймд уул уурхайн бус салбарыг хөгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх боломжийг судалж Монгол Улсад үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний дэлхийн зах зээл, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвар, давуу тал, тухайн салбарт тулгамдаж буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Аливаа улсын өрсөлдөх чадварыг тодорхойлж, бусад улстай харьцуулахад (i) дэлхийн эдийн засгийн форумаас тооцдог өрсөлдөх чадварын нэгдсэн индекс<sup>1</sup>, (ii) гадаад худалдааны нөхцөлийн индекс, (iii) бодит үйлчилж буй ханшийн индексийг түгээмэл ашигладаг. Гадаад худалдааны нөхцөлийн индекс, бодит үйлчилж буй ханшийн индекс зэрэг нь барааны гадаад худалдаанд Монгол Улсын үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн үнийн хувьд өрсөлдөх боломж байгаа эсэхийг харуулдаг. Дээрх хүчин зүйлсийн өнгөрсөн 3 жилийн дундаж өсөлтөөс үзэхэд гадаад худалдааны нөхцөл 4%-иар сайжирсан боловч бодит ханш 4%-иар чангарснаар Монгол Улсаас экспортлож буй бүтээгдэхүүн гадаад зах зээлд үнээр өрсөлдөх чадвар төдийлөн сайжраагүй байна. Өмнөх хоёр үзүүлэлттэй харьцуулахад өрсөлдөх чадварын нэгдсэн индекс нь тухайн улсын өрсөлдөх чадварыг бүтээмж, дэд бүтэц зэрэг нийт 150 гаруй хүчин зүйлд тулгуурлан тооцдоогоороо илүү өргөн агуулгатай. Энэхүү үзүүлэлт ч мөн адил сүүлийн 3 жилийн хугацаанд өөрчлөлт багатай буюу дунджаар 0.2%-иар буурч 2014 оны байдлаар 144 улсаас 98-д жагсаж байгаа нь Монгол Улсын өрсөлдөх чадвар сайжрахгүй байгааг илтгэж байна.<sup>2</sup>

Уг судалгааны ажлын хүрээнд гадаад худалдаанд харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнийг тодорхойлж тус бүлгийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар бүс нутгийн хэмжээнд, цаашлаад дэлхийн хэмжээнд ямар байгааг тодорхойлох, дэлхийн зах зээлд ямар чанарын стандарт шаарддаг, гадаад, дотоод зах зээлийн

<sup>1</sup> Монгол Улсын өрсөлдөх чадварын нэгдсэн индексийг тодорхойлогч үзүүлэлтүүдийг Хавсралт 1-ээс харна уу.


<sup>2</sup> 2011-2014 оны хооронд Монгол Улс өрсөлдөх чадварын нэгдсэн үзүүлэлтээр 93-107 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна. Үүнд макро эдийн засгийн орчны үзүүлэлтүүд сайжрахгүй байгаа нь голчлон нөлөөлжээ.

багтаамж, цаашид тус салбарын хүрч болох экспортын потенциал хэмжээг тодорхойлов. Улмаар судалгаагаар тодорхойлсон салбаруудын хэрэгцээ шаардлагад нийцтэйгээр төрөөс хэрэгжүүлэх бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох дэд зорилтууд дэвшүүлэн тус ажлыг гүйцэтгэлээ.

## 1. ЭДИЙН ЗАСГИЙН ХАРААТ БАЙДАЛ, ТӨВЛӨРӨЛ

Монгол Улсын эдийн засаг хэрэглээний шинж чанар давамгайлсан, боловсруулах үйлдвэрлэл сул хөгжсөн буюу сүүлийн 5 жилд ДНБ-ий ердөө 6%-ийг эзэлж байна. Улмаар уул уурхайн салбарын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх шууд нөлөө нэмэгдсээр байна.

Дүрслэл 1. Уул уурхайн ба Уул уурхайн бус ДНБ-ий өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Импортын хэмжээ дотоодын үйлдвэрлэлтэй харьцуулахад өндөр буюу 2000-2014 оны хооронд дунджаар Монгол Улсад жилийн турш үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний 66% (бараа, үйлчилгээний импорт/ДНБ)-ийг бүрдүүлж байна. Энэ нь дотоодод үйлдвэрлэл сул хөгжсөн, ихэнх бараа, үйлчилгээг гаднаас авдаг болохыг илэрхийлнэ.

### 1.1. Импортоос хараат байдлын харьцаа


Импортоос хараат байдлын харьцаа (import dependency ratio) нь тухайн улс импортоос хэр хамааралтай болохыг харуулах ба 0-ээс 1-ийн хооронд утга авна. Тус харьцааны утга 1-тэй ойрхон байх тусам импортоос хараат болохыг илтгэнэ.

$$IDR = \frac{M}{Y - X + M} \quad [1]$$

Энд:  $IDR$  ~ импортоос хараат байдлын харьцаа;  
 $M$  ~ бараа, үйлчилгээний импорт;  
 $X$  ~ бараа, үйлчилгээний экспорт;  
 $Y$  ~ дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ).

Монгол Улсын хувьд уул уурхайн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт хийгдэж, бүтээн байгуулалт эхэлснээр хөрөнгө оруулалтын импорт 2011 онд эрс нэмэгдэж импортоос хараат байдлын харьцаа өссөн.


### Дүрслэл 2. Монгол Улсын импортоос хараат байдлын харьцаа



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Харин сүүлийн жилүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал буурсантай холбоотойгоор хөрөнгө оруулалтын импорт буурч байна. Тухайлбал, 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт барааны импортын 40%-ийг хөрөнгө оруулалтын чанартай бараа эзэлж байгаа ба үүний 75%-ийг машин, тоног төхөөрөмжийн импорт дангаараа бүрдүүлж байна.

Дүрслэл 3. Монгол Улсын барааны импортын бүтэц



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Энэ нь уул уурхайн салбар Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурьтай хэвээр байгаагийн илрэл бөгөөд 2014 онд уул уурхайн салбар 24%-иар өсч, ДНБ-ий өсөлтийн 63%-ийг бий болгожээ.

Түүнчлэн экспортын төрөлжилт муу, нэг салбараас хамаарал өндөртэй байх нь эдийн засаг тогтворгүй болох эрсдэлийг нэмэгдүүлдэг. Иймд, Монгол Улсын гадаад худалдааны төвлөрлийг тодорхойлох зорилгоор зах зээлийн өрсөлдөөн, төвлөрлийг хэмжихэд өргөн ашиглагддаг Херфиндал-Хиршманы индексийг экспорт, импортын бараа болон түнш улсуудаар тооцлоо.

### 1.2 Гадаад худалдааны төвлөрөл

Тухайн улсын гадаад худалдааны төвлөрлийг Херфиндал-Хиршманы индекст (НИ) үндэслэн тодорхойлох боломжтой. Уг индексийг зах зээлийн өрсөлдөөнийг тодорхойлоход өргөн ашигладаг бөгөөд дараах байдлаар тооцно (Rhoades, 1993).

$$НИ = \sum_{i=1}^N s_i^2 \quad [2]$$

$s_i$  - пүүсийн зах зээлд эзлэх хувь;

$N$  - нийт пүүсийн тоо.

Херфиндал-Хиршманы индекс нь  $1/N$ -ээс 1-ийн хооронд утга авдаг.

**Хүснэгт 1. Төвлөрлийн түвшин**

Индексийн утга	Зах зээлийн төрөл
$HNI < 0.01(100)$	Төгс өрсөлдөөнт зах зээл
$0.01(100) < HNI < 0.15(1500)$	Төвлөрөлгүй зах зээл
$0.15(1500) < HNI < 0.25(2500)$	Дунд зэргийн төвлөрөлтэй зах зээл
$HNI > 0.25(2500)$	Их төвлөрөлтэй зах зээл


Индексийн утга бага гарах тусам өрсөлдөөн ихтэй, тухайн зах зээлд ноёрхогч этгээд бага болохыг илтгэнэ. Практикт нормчлогдсон Херфиндал-Хиршманы индексийг түгээмэл ашигладаг. Нормчлоогүй Херфиндал-Хиршманы индекс нь  $1/N$ -ээс 1-ийн хооронд утга авдаг бол нормчлогдсон индекс нь 0-ээс 1-ийн хооронд утгатай байна. Дараах тэгшитгэлийг ашиглан нормчлогдсон Херфиндал-Хиршманы индексийг тооцдог.


$$HNI^* = \frac{HNI - 1/N}{1 - 1/N} \tag{3}$$

Уг индексийг Монгол Улсын экспорт, импортын хувьд гадаад худалдааны түнш орнууд болон барааны бүлгээр тооцож дараах үр дүнд хүрлээ.

Монгол Улсын экспортын төвлөрөл 2006 оноос хойш улам бүр гүнзгийрсэн байна. Тухайлбал, 2014 оны байдлаар экспортлогч улсаар тооцсон НИИ индекс 0.776-тай тэнцүү байгаа нь төвлөрөл ихтэй зах зээлийн босго утгаас даруй 3.1 дахин өндөр байна. Үүнд Монгол Улсын экспортын гол худалдан авагч болох БНХАУ руу экспортлосон бүтээгдэхүүний хэмжээ нийт экспортын 99%-тай тэнцүү байсан нь голлох нөлөөг үзүүлсэн. Түүнчлэн бүтээгдэхүүний бүлгээр тооцсон индекс мөн уул уурхайн салбарын эрчимжилттэй уялдан өссөн байна.

**Дүрслэл 4. Монгол Улсын гадаад худалдааны төвлөрөл**





Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

2014 онд барааны импортын 90%-ийг 12 улсаас авсан ба маш олон нэр төрлийн барааг импортоор авдаг. Барааны импортын төвлөрлийг ННІ индексээр хэмжвэл 2014 оны байдлаар импортын түнш орнуудын хувьд 0.212, барааны төрлийн хувьд 0.147 гэсэн утгатай байна. Энэ нь барааны импорт түнш орнуудаар дунд зэрэг төвлөрөлтэй боловч барааны нэр төрлийн хувьд харьцангуй төвлөрөл багатай байгааг илэрхийлнэ.

## 2. ХАРЬЦАНГУЙ ДАВУУ ТАЛЫН ШИНЖИЛГЭЭ

### 2.1 Харьцангуй давуу талын индекс

1817 онд Рикардо харьцангуй давуу талын сонгодог онолыг хөгжүүлсэн бол Баласса 1965 оны бүтээлээрээ харьцангуй давуу талыг хэмжих индекс (Revealed Comparative Advantage-RCA)-ийг боловсруулжээ. Тус индексийг тухайн улсын тодорхой нэг бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жинг тухайн бүтээгдэхүүний дэлхийн нийт экспортод эзлэх хувийн жинд харьцуулсан байдлаар тодорхойлдог. Гэвч бүтээгдэхүүн тус бүрийг ялгаж үзэх боломжгүй, тодорхой хэдэн барааг нийлүүлэн авч үзсэн барааны бүлгийн хувьд харьцангуй давуу талыг тооцох тул тухайн барааны бүлгийн экспортоос гадна импортыг давхар авч үзэх шаардлагатай байдаг. Иймд Баласса харьцангуй давуу талын индексийг [4] тэгшитгэлээр тодорхойлсон.

$$w_{ij} = x_{ij}/m_{ij} \quad [4]$$

Энд  $x_{ij}$  нь экспортын индекс,  $m_{ij}$  нь импортын индекс болно. [4] тэгшитгэлээр тооцсон харьцангуй давуу талын индекс нь 1-ээс их ( $w_{ij} > 1$ ) байвал тухайн улс тухайн бүтээгдэхүүнийхээ хувьд гадаад худалдааны харьцангуй давуу талтай гэж ойлгоно. Өөрөөр хэлбэл, тухайн бүтээгдэхүүний цэвэр экспорт дэлхийн дунджаас өндөр байвал давуу талтай гэсэн үг.  $x_{ij}$  болон  $w_{ij}$ -ийг (5) болон (6) тэгшитгэлүүдээр тооцно.



$$x_{ij} = \left( X_{ij} / \sum_{i=1}^N X_{ij} \right) / \left( \sum_{j=1}^T X_{ij} / \sum_{i=1}^N \sum_{j=1}^T X_{ij} \right) \quad [5]$$

Энд  $X_{ij}$  нь  $j$ -р улсын  $i$ -р бүтээгдэхүүний экспортын үнийн дүн,  $T$  нь дэлхийн улс орнуудын тоо,  $N$  нь бүтээгдэхүүний бүлгийн тоо болно.  $\sum_{i=1}^N X_{ij}$  ба  $\sum_{i=1}^N \sum_{j=1}^T X_{ij}$  нь харгалзан жишиг болгон авч буй улсын нийт экспорт болон дэлхийн нийт экспортыг илэрхийлнэ. Хэрэв импортыг  $M$ -ээр тэмдэглэвэл,  $m_{ij}$  дараах байдлаар тодорхойлогдоно.

$$m_{ij} = \left( M_{ij} / \sum_{i=1}^N M_{ij} \right) / \left( \sum_{j=1}^T M_{ij} / \sum_{i=1}^N \sum_{j=1}^T M_{ij} \right) \quad [6]$$

Энд тэмдэглэгээ нь [5] тэгшитгэлийнхтэй адилхан бөгөөд [6] тэгшитгэл нь импортын хувьд тооцож буй индекс юм (Murrell, 1991).

## 2.2 Бүтээгдэхүүний ангилал

Харьцангуй давуу талыг хэмжихийн тулд бүтээгдэхүүний ангиллыг хэрхэн хийх талаар цөөнгүй судалгааны ажлууд байдаг. Hufbauer (1970), Hufbauer ба Chilas (1974) нар бүтээгдэхүүнийг зориулалтаар нь (i) хэрэглэгчдэд зориулсан буюу эцсийн бүтээгдэхүүн, (ii) үйлдвэрлэлд зориулсан буюу завсрын бүтээгдэхүүн гэж ангилсан байдаг.

### Хүснэгт 2. Бүтээгдэхүүний ангилал (Зориулалтаар)

	Бүлгийн нэр	Бүлгийн тодорхойлолт	Тухайн бүлэгт багтаж буй бүтээгдэхүүнүүд
1.	Хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүн	Эцсийн хэрэглэгчдэд зориулагдсан.	Анагаах ухааны болон эм зүйн бүтээгдэхүүн, үнэртэй ус, саван, аяллын хэрэгслүүд, хувцас, гутал, оймс
2.	Үйлдвэрлэлд зориулсан бүтээгдэхүүн	Үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтад голчлон ашиглагддаг завсрын бүтээгдэхүүн.	Органик бус химийн бүтээгдэхүүн, радио идэвхит бүтээгдэхүүн, будагч бодис, фанер, барилгын материал, уул уурхайн үйлдвэрт төхөөрөмж, төмөр ба ган, метал, машины багаж хэрэгсэл, электрон машин, тээврийн хэрэгсэл

Эх сурвалж: Hufbauer (1970) болон Hufbauer and Chilas (1974)

Харин шинж чанар, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн ач холбогдлоос нь хамааруулж Рикардогийн бүтээгдэхүүн (Ricardo goods), Хекшир-Олины (Heckscher-Ohlin goods) бүтээгдэхүүн, Мөчлөгтэй бүтээгдэхүүн (Product Cycles goods) гэж 3 ангилсан.

**Хүснэгт 3. Бүтээгдэхүүний ангилал (Технологийн түвшнээр)**

	Бүлгийн нэр	Бүлгийн тодорхойлолт	Тухайн бүлэгт багтаж буй бүтээгдэхүүнүүд
1.	Рикардогийн бүтээгдэхүүн	Байгалийн баялаг түлхүү ашиглаж хийгддэг.	Хүнс, мод, мяндас, ашигт малтмал, цаас, өнгөт бус метал, газрын тос, төмрийн хүдэр, түүхий нефть
2.	Хекшир-Олины бүтээгдэхүүн	Стандарт технологи ашиглаж хийгддэг (хөдөлмөр, капиталын хувьд өргөжилтийн тогтмол үр өгөөжтэй).	Ундаа, тамхи, цемент, шалны хамгаалалт, шил, шавар эдлэл, өнгөт метал, машин, метал бүтээгдэхүүнүүд, хөдөлгүүр, усан онгоц, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, ном, тавилга, хувцас, үнэт эдлэл, бичгийн хэрэгсэл
3.	Мөчлөгтэй бүтээгдэхүүн	Өндөр технологи ашиглан хийгддэг.	Химийн бүтээгдэхүүн, эм, хуванцар, хурдасгуур, авто машин, нисэх онгоц, цаг, зэр зэвсэг, дэлбэрэгч бодис

Эх сурвалж: *Hufbauer (1970)* болон *Hufbauer and Chilas (1974)*

**2.3 Монгол Улсын гадаад худалдааны харьцангуй давуу талын шинжилгээ**

**2.3.1 Өгөгдлийн тодорхойлолт**

Харьцангуй давуу талын индексийг тооцохын тулд энэхүү судалгааны ажилд дараах өгөгдлийг холбогдох эх сурвалжуудаас авч, ашиглалаа.

**Хүснэгт 4. Өгөгдлийн тодорхойлолт**

Өгөгдлийн нэр	Хамрах хүрээ	Эх сурвалж	Нэгж
Дэлхийн экспорт (бараагаар)	2001-2013	www.trademap.org	Ам.доллар
Дэлхийн импорт (бараагаар)	2001-2013	www.trademap.org	Ам.доллар
Монгол Улсын экспорт (бараагаар)	2001-2013	www.trademap.org, www.customs.gov.mn	Ам.доллар
Монгол Улсын импорт (бараагаар)	2001-2013	www.trademap.org, www.customs.gov.mn	Ам.доллар

**2.3.2 Шинжилгээний үр дүн**

Монгол Улс нь хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүний хувьд харьцангуй давуу талгүй, харин үйлдвэрлэгчдэд зориулсан бүтээгдэхүүн буюу завсрын бүтээгдэхүүний хувьд давуу талтай байна. Гэхдээ тухайн ангилал доторх зарим нэг бүтээгдэхүүн нь харьцангуй давуу талтай байх тохиолдол ажиглагдсан. Дэлгэрэнгүй тооцооллыг Хавсралт 2 болон Хавсралт 3-аас харна уу.

**Хүснэгт 5. Хэрэглэгч болон Үйлдвэрлэлд зориулсан бүтээгдэхүүний харьцангуй давуу тал**

		2001	2003	2005	2007	2009	2011	2013
Хэрэглэгчдэд зориулсан аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд	x	1.097	0.833	0.635	0.329	0.306	0.185	0.178
	m	1.200	1.130	1.062	1.068	1.014	0.701	0.830
	w	0.914	0.737	0.598	0.308	0.301	0.263	0.214
Үйлдвэрлэгчдэд зориулсан аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд	x	4.071	3.343	3.253	3.870	3.982	2.009	2.943
	m	1.997	1.726	1.832	1.722	1.368	1.273	1.104
	w	2.038	1.937	1.776	2.248	2.911	1.578	2.665

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Хэрэглэгчдэд зориулсан аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ангилалд багтах нийт 51 нэр төрлийн бараанаас дараах 2 төрлийн бүтээгдэхүүний хувьд харьцангуй давуу талтай байна. Энд w мөрийн тоон утга 1-ээс их байвал харьцангуй давуу талтай гэж ойлгоно.

**Хүснэгт 6. Харьцангуй давуу талтай хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүн**

		2001	2003	2005	2007	2009	2011	2013	
1.	Сүлжмэл хувцас болон хувцсанд хэрэглэх сүлжмэл зүйлс	x	4.57	6.30	3.92	1.82	0.55	0.49	0.52
		m	0.24	0.94	0.68	0.15	0.08	0.08	0.13
		w	18.87	6.67	5.76	12.27	6.64	5.93	4.01
2.	Амьтны гаралтай бүтээгдэхүүн	x	27.23	19.96	17.00	8.59	7.70	5.97	5.49
		m	0.04	0.12	0.16	0.04	0.05	0.01	0.00
		w	734.77	165.99	105.00	213.50	157.67	851.50	1392.90

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Үйлдвэрлэлд зориулсан аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ангилалд багтах багтах нийт 46 нэр төрлийн бараанаас доорх 10 төрлийн бүтээгдэхүүн харьцангуй давуу талтай байна.

**Хүснэгт 7. Харьцангуй давуу талтай үйлдвэрлэлд зориулсан бүтээгдэхүүн**

		2001	2003	2005	2007	2009	2011	2013	
1.	Зэс ба зэс эдлэл	x	0.88	0.73	1.11	1.06	0.75	0.42	0.44
		m	0.20	0.07	0.06	0.06	0.05	0.07	0.04
		w	4.27	10.10	17.23	17.13	15.20	6.00	11.11
2.	Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн, битумын эрдэс, эрдэс лав	x	0.08	0.21	0.27	0.61	1.56	2.95	2.26
		m	2.25	1.99	1.95	1.99	1.78	1.02	1.44
		w	0.04	0.11	0.14	0.31	0.88	2.89	1.57

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БҮТЦИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ БОЛОМЖУУД

3.	Хүдэр, шаар ба нурам	x	68.52	59.17	44.24	50.60	35.78	20.74	29.02
		m	0.02	0.05	0.01	0.00	0.00	0.01	0.00
		w	3 022.21	1 107.97	6 581.71	13 147.40	7 952.67	2 129.87	44 277.25
4.	Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт метал, гоёлын зүйлс, зоос	x	0.08	11.59	15.75	5.83	7.10	0.74	1.11
		m	0.00	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.01
		w	31.57	1 426.46	1 790.99	434.10	479.91	58.87	97.64
5.	Мал, амьтны нарийн болон бүдүүн ширхэгт үс, хялгас	x	83.39	49.92	67.79	99.76	117.36	51.88	84.32
		m	8.55	7.45	2.88	1.75	0.59	0.39	0.48
		w	9.75	6.71	23.54	56.85	198.76	134.01	177.35
6.	Арьс ширэн түүхий эд (үслэг арьснаас бусад) болон боловсруулсан арьс, шир	x	13.57	10.65	7.39	7.30	7.83	6.42	7.03
		m	2.70	3.41	3.77	4.94	4.26	3.95	6.66
		w	5.03	3.12	1.96	1.48	1.84	1.63	1.06
7.	Давс, хүхэр, шороо ба чулуу, шаваасны материал, шохой ба цемент	x	13.57	10.65	7.39	7.30	7.83	6.42	7.03
		m	2.70	3.41	3.77	4.94	4.26	3.95	6.66
		w	5.03	3.12	1.96	1.48	1.84	1.63	1.06
8.	Хар тугалга, түүгээр хийсэн зүйлс	x	1.87	5.77	0.65	0.51	0.08	0.34	0.28
		m	0.06	0.16	0.74	0.00	0.16	0.14	0.07
		w	29.64	36.02	0.88	490.58	0.51	2.40	4.19
9.	Хүнсний үйлдвэрээс гарсан үлдэгдэл ба хаягдал, малын тэжээлийн бэлдмэл	x	0.15	0.00	0.07	0.01	0.00	0.07	0.22
		m	0.18	0.07	0.14	0.21	0.28	0.17	0.17
		w	0.86	0.06	0.50	0.04	0.01	0.42	1.27
10.	Тослог үр ба жимс, бусад үр жимс, сүрэл ба малын тэжээл	x	0.03	0.09	0.06	0.42	0.49	0.19	0.22
		m	0.62	0.10	0.17	0.11	0.34	0.04	0.06
		w	0.05	0.90	0.37	3.87	1.46	5.15	3.94

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Монгол Улсын гадаад худалдааны бүтцийг технологийн түвшингээр нь ангилвал дараах байдлаар үнэлэгдэнэ.

Монгол Улсын гадаад худалдааны бүтцэд түүхий эд буюу Рикардогийн бүтээгдэхүүн 95-аас дээш хувийг эзэлж байна. Энэ нь Монгол Улс байгалийн баялаг, нөөцтэй, түүгээрээ харьцангуй давуу талтай болохыг илтгэнэ. Гэвч Рикардогийн бүтээгдэхүүн нь байгалийн нөөц ихээхэн ашиглагддаг, боловсруулалт муутай, нэмүү өртөг бага шингэсэн байдаг тул энэ төрлийн худалдааны бүтэц үр өгөөж хамгийн муутай байдаг.

Иймд Монгол Улс нь Хекшир-Олины бүтээгдэхүүн буюу стандарт технологи ашиглан өргөжилтийн тогтмол үр өгөөжтэй<sup>3</sup> бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг

<sup>3</sup> Constant returns to scale – Тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ахиу орлого, ашиг нь буурахгүй.

хөгжүүлэх хэрэгтэй.

**Хүснэгт 8. Монгол Улсын гадаад худалдааны барааны бүтэц (технологийн түвшингээр)**

	2001	2003	2005	2007	2009	2011	2013
Рикардогийн бүтээгдэхүүн	75.2%	79.3%	88.8%	94.3%	97.6%	98.6%	97.3%
Хекшир-Олины бүтээгдэхүүн	24.2%	19.9%	10.8%	4.9%	1.5%	1.0%	1.5%
Мөчлөгтэй бүтээгдэхүүн	0.6%	0.8%	0.5%	0.9%	0.9%	0.4%	1.2%
НИЙГ ЭКСПОРТ	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Тухайлбал, Хойд Солонгос 1970-1992 онд гадаад худалдааны бүтцээ Рикардогийн бүтээгдэхүүнээс Хекшир-Олины бүтээгдэхүүн рүү шилжүүлсэн байдаг. Тодруулбал, тус улс нь байгалийн баялаг түлхүү ашиглагддаг бүтээгдэхүүнээс стандарт технологи ашиглагддаг бүтээгдэхүүн рүү шилжих замаар эдийн засгийн бүтцээ хөгжүүлсэн байна (Lim, 1997).

Хекшир-Олины бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг болсны дараах алхам бол Үйлдвэрлэлийн мөчлөгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл юм. Энэ ангилалд багтах бүтээгдэхүүнүүд нь дэвшилтэт технологи ашиглан хийгддэг бүтээгдэхүүнүүд байдаг.

Нийт 43 төрлийн Рикардогийн бүтээгдэхүүнээс Монгол Улс нь дараах бүтээгдэхүүний хувьд харьцангуй давуу талтай байна.

**Хүснэгт 9. Харьцангуй давуу талтай Рикардогийн бүтээгдэхүүн**

		2001	2003	2005	2007	2009	2011	2013	
1.	Амьтны гаралтай бүтээгдэхүүн	x	27.23	19.96	17.00	8.59	7.70	5.97	5.49
		m	0.04	0.12	0.16	0.04	0.05	0.01	0.00
		w	734.77	165.99	105.00	213.50	157.67	851.50	1392.90
2.	Зэс ба зэс эдлэл	x	0.88	0.73	1.11	1.06	0.75	0.42	0.44
		m	0.20	0.07	0.06	0.06	0.05	0.07	0.04
		w	4.27	10.10	17.23	17.13	15.20	6.00	11.11
3.	Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн, битумын эрдэс, эрдэс лав	x	0.08	0.21	0.27	0.61	1.56	2.95	2.26
		m	2.25	1.99	1.95	1.99	1.78	1.02	1.44
		w	0.04	0.11	0.14	0.31	0.88	2.89	1.57
4.	Хүдэр, шаар ба нурам	x	68.52	59.17	44.24	50.60	35.78	20.74	29.02
		m	0.02	0.05	0.01	0.00	0.00	0.01	0.00
		w	3022.21	1107.97	6581.71	13147.40	7952.67	2129.87	44277.25
5.	Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт метал, гоёлын зүйлс, зоос	x	0.08	11.59	15.75	5.83	7.10	0.74	1.11
		m	0.00	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.01
		w	31.57	1426.46	1790.99	434.10	479.91	58.87	97.64

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БҮТЦИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ БОЛОМЖУУД

6.	Мал, амьтны нарийн болон бүдүүн ширхэгт үс, хялгас	x	83.39	49.92	67.79	99.76	117.36	51.88	84.32
		m	8.55	7.45	2.88	1.75	0.59	0.39	0.48
		w	9.75	6.71	23.54	56.85	198.76	134.01	177.35
7.	Арьс ширэн түүхий эд (үслэг арьснаас бусад) болон боловсруулсан арьс, шир	x	13.57	10.65	7.39	7.30	7.83	6.42	7.03
		m	2.70	3.41	3.77	4.94	4.26	3.95	6.66
		w	5.03	3.12	1.96	1.48	1.84	1.63	1.06
8.	Давс, хүхэр, шороо ба чулуу, шаваасны материал, шохой ба цемент	x	13.57	10.65	7.39	7.30	7.83	6.42	7.03
		m	2.70	3.41	3.77	4.94	4.26	3.95	6.66
		w	5.03	3.12	1.96	1.48	1.84	1.63	1.06
9.	Хар тугалга, түүгээр хийсэн зүйлс	x	1.87	5.77	0.65	0.51	0.08	0.34	0.28
		m	0.06	0.16	0.74	0.00	0.16	0.14	0.07
		w	29.64	36.02	0.88	490.58	0.51	2.40	4.19
10.	Тослог үр ба жимс, бусад үр жимс, сүрэл ба малын тэжээл	x	0.03	0.09	0.06	0.42	0.49	0.19	0.22
		m	0.62	0.10	0.17	0.11	0.34	0.04	0.06
		w	0.05	0.90	0.37	3.87	1.46	5.15	3.94

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Харин Хекшир-Олины 41 төрлийн бүтээгдэхүүнээс дараах 2 төрлийн бүтээгдэхүүнд харьцангуй давуу талтай.

**Хүснэгт 10. Харьцангуй давуу талтай Хекшир-Олины бүтээгдэхүүн**

			2001	2003	2005	2007	2009	2011	2013
1.	Сүлжмэл хувцас болон хувцсанд хэрэглэх сүлжмэл зүйлс	x	4.57	6.30	3.92	1.82	0.55	0.49	0.52
		m	0.24	0.94	0.68	0.15	0.08	0.08	0.13
		w	18.87	6.67	5.76	12.27	6.64	5.93	4.01
2.	Хүнсний үйлдвэрээс гарсан үлдэгдэл ба хаягдал, малын тэжээлийн бэлдмэл	x	0.15	0.00	0.07	0.01	0.00	0.07	0.22
		m	0.18	0.07	0.14	0.21	0.28	0.17	0.17
		w	0.86	0.06	0.50	0.04	0.01	0.42	1.27

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Мөчлөгтэй бүтээгдэхүүний ангилалд багтах ямар ч бүтээгдэхүүнд манай улс харьцангуй давуу талгүй байна. Энэ нь Монгол Улсад технологи, дэд бүтэц, логистик сул хөгжсөн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспорт муу байгааг илэрхийлнэ.

Доорх шинжилгээнд үндэслэн Монгол Улс дараах нийт 12 нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд харьцангуй давуу талтай гэж үзлээ.

**Хүснэгт 11. Монгол Улсын харьцангуй давуу талтай бүтээгдэхүүн**

	Барааны нэр	Барааны нэр	Барааны нэр
1.	Амьтны гаралтай бүтээгдэхүүн	5. Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт метал, гоёлын зүйлс, зоос	9. Хар тугалга, түүгээр хийсэн зүйлс
2.	Зэс ба зэс эдлэл	6. Мал, амьтны нарийн болон бүдүүн ширхэгт үс, хялгас	10. Тослог үр ба жимс, бусад үр жимс, сүрэл ба малын тэжээл
3.	Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн, битумын эрдэс, эрдэс лав	7. Арьс ширэн түүхий эд (үслэг арьснаас бусад) болон боловсруулсан арьс, шир	11. Сүлжмэл хувцас болон хувцсанд хэрэглэх сүлжмэл зүйлс
4.	Хүдэр, шаар ба нурам	8. Давс, хүхэр, шороо ба чулуу, шаваасны материал, шохой ба цемент	12. Хүнсний үйлдвэрээс гарсан үлдэгдэл ба хаягдал, малын тэжээлийн бэлдмэл

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Хүснэгт 11-д харуулсан 12 дэд бүлгийн барааны дэлгэрэнгүй задаргааг Хавсралт 4-өөс харна уу. Сүүлийн 5 жилийн дотор харьцангуй давуу талтай бүтээгдэхүүний сагс хэрхэн өөрчлөгдсөнийг Хүснэгт 12-оос харна уу.

2009 онд Монгол Улс нь нийт 16 бүтээгдэхүүний хувьд харьцангуй давуу талтай байсан бол 2013 онд 12 бүтээгдэхүүн болж буурчээ. Дэлхийн мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ тогтвортой нэмэгдэж байгаа хэдий ч харьцангуй давуу талтай бүтээгдэхүүний сагснаас (i) Амьд мал, амьтан, (ii) Мах ба хүнсний дайвар бүтээгдэхүүн, (iii) Махан бүтээгдэхүүн гэсэн ангиллын бүтээгдэхүүн жил ирэх тусам хасагдаж байна. Энэ нь Монголын мах, махан бүтээгдэхүүн эрүүл ахуй, чанарын хувьд олон улсын шаардлага, стандартыг хангах нь муу, олон улсын таваарын захтай холбоогүй буюу гадаад худалдааны сүлжээ, логистик хөгжөөгүй тул дэлхийн мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээний өсөлтөд нийцүүлж экспортоо нэмэгдүүлж чадахгүй байгаатай холбоотой. Эсрэгээрээ Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний импорт сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна.

**Хүснэгт 12. Харьцангуй давуу талтай бүтээгдэхүүний сагсны өөрчлөлт (индекс)**

Барааны бүлэг (БТКУС <sup>4</sup> -ийн 2 орноор)	2009	2010	2011	2012	2013
1. Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн, битумын эрдэс, эрдэс лав		1.614	2.885	2.270	1.572
2. Сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эр)	6.640	6.424	5.931	5.052	4.007
3. Хүдэр, шаар ба нурам	7,952.666	2,466.838	2,129.867	1,484.959	44,277.248
4. Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт метал, гоёлын зүйлс, зоос	479.908	123.965	58.872	79.821	97.638
5. Мал, амьтны нарийн болон бүдүүн ширхэгт үс, хялгас	198.764	82.584	134.005	117.537	177.352
6. Давс, хүхэр, шороо ба чулуу, шаваасны материал, шохой ба цемент	1.836	1.663	1.626	1.388	1.056

<sup>4</sup> Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем

7.	Зэс ба зэс эдлэл	15.198	8.745	6.002	8.639	11.108
8.	Арьс ширэн түүхий эд (үслэг арьснаас бусад) болон боловсруулсан арьс, шир	4,912.197	779.942	199.420	72.011	34.183
9.	Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн	157.668	35.676	851.497	3,508.372	1,392.896
10.	Тослог үр ба жимс, бусад үр жимс, сүрэл ба малын тэжээл	1.459		5.149	3.585	3.937
11.	Хар тугалга, түүгээр хийсэн зүйлс		18.848	2.400		4.189
12.	Хүнсний үйлдвэрээс гарсан үлдэгдэл ба хаягдал, малын тэжээлийн бэлдмэл					1.270
13.	Хивс болон нэхмэл дэвсгэрэн зүйлс	1.970	2.080	2.157	2.307	
14.	Амьд мал, амьтан	25.109	8.536	1.459	1.829	
15.	Мах ба хүнсний дайвар бүтээгдэхүүн	7.083	7.641	2.485		
16.	Мод, сөөг ургамал, модлог ургамлын суулгац	2.284		1.022		
17.	Урлагийн бүтээл, цуглуулга хийх зориултын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	1.397	1.134			
18.	Агаарын тээврийн хэрэгсэл, сансрын аппарат ба тэдгээрийн эд анги		1.083			
19.	Махан бүтээгдэхүүн	1.158				
20.	Үслэг арьс ба хиймэл үслэг арьс, эдгээрээр хийсэн эдлэл	4.909				

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

### 3. УУЛ УУРХАЙН БУС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Энэхүү бүлэгт Монгол Улсын харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнүүдээс хамгийн өндөр үнийн дүн бүхий (i) ноос, ноолуур, (ii) арьс, шир гэсэн 2 төрлийн бүтээгдэхүүний зах зээл, цаашид тэдгээрийн экспортыг нэмэгдүүлэх боломжийг судлах болно (Хавсралт 4). Ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний зах зээлийн судалгааг хийхдээ Монгол Улсын Аж үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газар (ХҮБЗГ)-тай хийсэн уулзалт болон ХҮБЗГ-аас авсан мэдээлэлд үндэслэсэн болохыг тэмдэглэх нь зүйтэй.

#### 3.1 Арьс, шир боловсруулах салбар

##### 3.1.1 Арьс, шир боловсруулах салбарын өнөөгийн байдал

Дэлхийн хүн ам өсөн нэмэгдэхийн хэрээр арьс ширэн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ дэлхийн зах зээлд тасралтгүй нэмэгдэж байна. Тухайлбал дэлхийн түүхий арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 32.2 тэрбум ам.доллараар хэмжигдэж буйгаас хамгийн том хэрэглэгч болох БНХАУ 8.0 тэрбум ам.доллар буюу дэлхийн нийт арьс шир үйлдвэрлэлийн 25%-ийг дангаар импортлосон байна.



**Хүснэгт 13. Дэлхийн улс орнуудаас Азийн улсуудтай хийсэн арьс ширний бүлгийн бүтээгдэхүүний гадаад худалдаа, мян.ам.доллар**

	2010		2011		2012		2013	
	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт
БНСУ	655,680	205,497	759,746	254,514	808,591	245,853	954,940	271,544
БНХАУ	261,876	1,807,022	317,335	1,860,079	345,632	1,951,540	378,760	2,112,783
Итали	1,475,007	476,480	1,659,077	639,175	1,508,187	585,637	1,776,053	614,263
Орос	17,324	17,324	22,011	22,011	21,204	21,204	16,194	16,194
<b>Нийт</b>	<b>2,409,887</b>	<b>2,506,323</b>	<b>2,758,169</b>	<b>2,775,779</b>	<b>2,683,614</b>	<b>2,804,234</b>	<b>3,125,947</b>	<b>3,014,784</b>

Эх сурвалж: [www.trademap.org](http://www.trademap.org)

Монгол Улсын арьс ширэн бүтээгдэхүүн нийлүүлж буй улс орнуудын Азийн улсуудаас авч буй арьс ширэн бүтээгдэхүүний импорт 2013 оны байдлаар 3 тэрбум ам.доллараар хэмжигддэг. Гэтэл Монгол Улсаас экспортлож буй бүтээгдэхүүний хэмжээ энэ төрлийн бүтээгдэхүүний 1.2%-тай тэнцэж байна. Гадаад зах зээлд боловсруулсан арьс шир, түүгээр хийсэн бэлэн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ их, Европын холбооны орнуудад квотгүй экспортлох боломжтой ч манай улсын арьс ширэн бүтээгдэхүүний экспортын 90 гаруй хувийг хагас боловсруулсан арьс шир эзэлж байна<sup>5</sup>. Монгол Улс мал сүргийн арвин нөөцтэй боловч арьс, шир боловсруулах, арьс ширэн эдлэл, гутал үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүний дүн боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 1 хүрэхгүй хувийг эзэлж байна.<sup>6</sup> Монгол Улс жилд дунджаар бод, бог малын нийт 10 сая ширхэг арьс бэлтгэж байгаагаас 2013 оны байдлаар 25% буюу 38 тэрбум төгрөгийн түүхий эдийг үндэсний үйлдвэрүүд худалдан авч, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үлдсэн 75% буюу 101 тэрбум төгрөгийн түүхий эдийг БНХАУ-ын арьс ширний ченжүүд болон тэдгээртэй шууд хамааралтай ажилладаг дотоодын ченжүүд худалдан авч, үүнээс 35.6 сая ам.долларын бүтээгдэхүүн экспортлосон байна.

**Хүснэгт 14. арьс, ширний бүлгийн бүтээгдэхүүний гадаад худалдаа<sup>7</sup>, мян.ам.доллар**

	2010		2011		2012		2013		2014	
	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт
БНСУ	326.9	1.8	1,078.4	0.1	585.9	0.0	196.2	372.9	1.1	378.3
БНХАУ	25,670.8	3.1	42,475.2	0.7	25,788.9	0.1	27,891.6	27.9	27,223.5	49.6
Итали	4,599.2	0.0	6,126.4	77.4	3,179.5	3.4	6,285.8	0.0	7,570.4	2.7
Орос	1.0	33.1	2.0	260.0	2.3	278.5	0.1	1,034.3	1.7	903.0
Бусад	1,154.5	14.8	1,130.0	26.0	722.8	411.6	453.2	142.8	782.2	203.4
<b>Нийт</b>	<b>31,752.3</b>	<b>52.8</b>	<b>50,812.0</b>	<b>364.2</b>	<b>30,279.4</b>	<b>693.6</b>	<b>34,826.9</b>	<b>1,578.0</b>	<b>35,578.8</b>	<b>1 537.0</b>

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар


<sup>5</sup> Вет-блю хэлбэрээр экспортлосон.

<sup>6</sup> Эх сурвалж: ҮСХ-ны аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн мэдээ.

<sup>7</sup> БТКУС-ийн 8 орны кодоор 41-ээр эхэлсэн бүх барааны нийлбэр дүн.

Хагас боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүнээр Монгол Улс харьцангуй давуу талтай байдаг бөгөөд тус бүлгийн бүтээгдэхүүний гадаад эрэлт ч өндөр байдаг. Гэвч энэ төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ боломжит дээд түвшиндээ дөхсөн боловч экспортоор олж буй орлогын түвшин хангалтгүй байна. Арьс ширэн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин бүрт харгалзах нэмүү өртөг харилцан адилгүй байдаг бөгөөд анхан шатны боловсруулалт хийн экспортлох түвшинд нэмүү өртөг бага шингэдэг бөгөөд түүхий эдийн үнэ дээр ердөө 18% нэмэгддэг.

**Дүрслэл 5. Боловсруулалтын түвшинд харгалзах нэмүү өртөг**



Эх сурвалж: Аж үйлдвэрийн яам

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн анхан ба дунд шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн чанарын стандартад нийцдэг, гологдол багатай боловч энэ түвшинд боловсруулсан бүтээгдэхүүнд нэмүү өртөг бага шингэдэг. Харин арьс ширийг гүн боловсруулах, түүгээр хийсэн бэлэн бүтээгдэхүүнд шингэх өртөг харьцангуй өндөр байдаг.

Гэвч Монгол Улсын арьс шир үйлдвэрлэгчдийн технологийн түвшин дэлхийн стандартаас хоцорсон, үйлдвэрлэлийн хүчин чадал хязгаарлагдмал байгаагаас гүйцэд боловсруулсан арьс, бэлэн бүтээгдэхүүний чанар хангалтгүй байна. Энэ нь Монгол улсад үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүний экспорт төдийлөн нэмэгдэхгүй, борлуулах үнэ хамгийн багадаа 30%-иар доогуур байгаагаас тодорхой харагдана. Үүнээс Монгол Улсын үйлдвэрлэгчийн өнөөгийн байдлыг судлан үзэхэд арьс ширийг гүн боловсруулах, цаашлаад түүгээр үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай нь харагдаж байна. 2014 оны эцсийн байдлаар тус салбарт төрийн өмчит 1, хувьцаат 7, хувийн хэвшлийн 30 гаруй арьс шир боловсруулах үйлдвэр ажиллаж байгаа бөгөөд жилд 18 сая ширхэг хүртэл арьс ширийг анхан шатны боловсруулалт хийх, 6.3 сая ширхэг арьс ширийг гүн боловсруулах хүчин чадалтай байна. Улмаар боловсруулах үйлдвэрээс гарсан түүхий эдийг ашиглан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 30 гаруй аж ахуйн нэгж тус салбарт ажиллаж байгаа боловч түүхий эдийн дийлэнх хэсгийг хагас боловсруулан экспортлож байна.<sup>8</sup>

<sup>8</sup> Аж үйлдвэрийн яам, үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн мэдээ.

Түүнчлэн арьс ширэн жижиг бүтээгдэхүүний үйлдвэрлэгчид 1.5 сая ам.доллартай тэнцэхүйц арьс, туслах материалыг БНХАУ, БНСУ, ОХУ зэрэг улсаас импортоор авч байна. Энэ нь дотоодод үйлдвэрлэж буй түүхий эдийн нөөц улирлын чанартай, дийлэнх хэсгийг экспорлодог, бэлтгэсэн түүхий эдийн чанар хангалтгүй байдагтай холбоотой.

### 3.1.2 Арьс, шир боловсруулах салбарын хүндрэлтэй асуудлууд

Арьс ширний салбарын үйлдвэрүүд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадахгүй байгаа гол шалтгаан нь санхүүгийн эх үүсвэр болон хүний нөөцийн чадавхи хангалтгүй, түүхий эдийн чанар муу, түүхий эд нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо байхгүйтэй холбоотой байна. Түүнчлэн боловсруулах үйлдвэрүүд техникийн шинэчлэл хийхгүй удсан, өндөр чанартай, олон улсын стандартад нийцсэн химийн материал, бусад бодис худалдан авч үйлдвэрлэлд ашиглаж чадахгүй байгаа нь түүхий эд бэлтгэлийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

#### Хүснэгт 15. Арьс, ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн шийдвэрлэх гол асуудлууд

Хүндрэлтэй асуудал	Шалтгаан, үр дүн
Түүхий эдийн чанар муу	<ul style="list-style-type: none"> <li>- Малчид малаа вакцинжуулалт, угаалгад хамруулдаггүйгээс арьсанд хачиг, гуурын сорви үүссэн байдаг.</li> <li>- Мал нядлах, арьс ширийг өвчих явцад цоолж гэмтээх, чанарын хамгаалалт хийхгүйгээр хадгалалт, тээвэрлэлт хийдгээс шалтгаалан гэмтэл үүсдэг.</li> </ul> <p>Боловсруулалт хийгдсэн нийт арьс ширний 30 хувь нь арьсан хүрэм, бусад хувцас үйлдвэрлэх шаардлага хангахгүй байна.</p>
Түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо байхгүй, үнэ өндөр	<ul style="list-style-type: none"> <li>- Түүхий эдийн 99 хувь нь орон нутагт үйлдвэрлэгддэг ч 90 гаруй хувийг Улаанбаатар, Дархан хот дахь арьс ширний үйлдвэрүүдэд боловсруулдаг.</li> <li>- Мөн түүхий эдийн төвлөрсөн зах байхгүй, түүхий эд нийлүүлэлтийн суваг оновчтой бүрэлдэж чадаагүйгээс үйлдвэрлэгчидэд түүхий эдийн хомсдол, тасалдал гардаг бөгөөд түүхий эдээ гадны үйлдвэрлэгчдэд алдах тохиолдол түгээмэл байдаг.</li> <li>- Шатахууны үнэ, инфляци, тээврийн зардал зэрэг хүчин зүйлээс шалтгаалж боловсруулах үйлдвэр дээр ирэх түүхий эдийн өртөг нэмэгддэг.</li> </ul>
Тоног төхөөрөмж хоцрогдсон, үйлдвэрлэлийн нөхцөл муу.	<ul style="list-style-type: none"> <li>- Технологи хэт хуучирсан бөгөөд засвар үйлчилгээний зардал их, бүтээмж багатай.</li> <li>- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар өнгө үзэмж өрсөлдөгч бусад орны бүтээгдэхүүнтэй харьцуулахад доогуур.</li> <li>- Үйлдвэрүүдийн гаднах инженерийн шугам сүлжээ элэгдэлд орсоны улмаас хөрс бохирдуулах эрсдэлтэй болсон.</li> <li>- Арьс ширний үйлдвэрлэлд хэрэглэгддэг хром гэх мэтийн химийн бодисууд нь үйлдвэрлэлийн хүнд хортой нөхцөлийг бий болгодог.</li> <li>- Үйлдвэрлэлийн ус цэвэрлэх төв “Харгиа” байгууламжийн үйл ажиллагаанаас болж арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа доголддог.</li> </ul>
Боловсон хүчин дутмаг	<ul style="list-style-type: none"> <li>- Арьс шир боловсруулах үе шатанд нарийн мэргэшсэн хүний нөөц дутагдалтай</li> <li>- Түүхий эдээ хангалттай нөөцөлж чаддаггүйн улмаас үйлдвэрүүд бүрэн хүчин чадлаа ашиглаж чадахгүй 5-6 сар сул зогсдог тул мэргэшсэн боловсон хүчин ховордсон.</li> </ul>

Эргэлтийн хөрөнгө дутмаг	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэл эрхлэгчдийн 90 гаруй хувь нь мал нядлах богинохон хугацаа буюу 9-11 дугаар сард эргэлтийн хөрөнгийн хомсдолд ордог, БНХАУ-ын түүхий эдийн ченж, компаниудтай өрсөлдөх чадваргүй байдаг.</li> <li>- Банкны зээлийн хугацаа богино.</li> <li>- Дэд бүтэц, технологи, үйлдвэрлэлийн нөхцөл муугаас шалтгаалан хөрөнгө оруулалт татах боломж бага.</li> </ul>
Нэгдсэн бодлого байхгүй	<ul style="list-style-type: none"> <li>- Хувьчлалаар бие биенээсээ технологийн хамааралтай үйлдвэрүүдийн цогц байдал алдагдаж, эмх замбараагүй болсон.</li> <li>- Түүхий эдийн бэлтгэл нийлүүлэлт, боловсруулалт, үйлдвэрлэл, борлуулалтын нэгдсэн тогтолцоо байхгүй.</li> <li>- Технологийн дэвшил нэвтрүүлэх болон гадаад зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэх боломжийн талаар судалгаа шинжилгээний ажлууд маш бага хийгдсэн.</li> <li>- Салбарын талаар баримтлах нэгдсэн стратеги, хөгжлийн бодлого тодорхой биш байна.</li> </ul>

### Шигтгээ 1. Арьс, шир боловсруулах салбарын бүтээгдэхүүний стандарт ба Монгол Улс

Монгол Улсад анхан шатны боловсруулалт хийсэн бүх төрлийн арьс, ширний чанарын үзүүлэлтийг тодорхойлоход MNS 4724:2001-ийг баримталдаг. Тус стандартад арьс шир боловсруулах техникийн шаардлагыг дараах байдлаар заасан байдаг.

- ◆ Үслэг эдлэлийн зориулалттайгаас бусад анхан шатны боловсруулалт хийсэн бүх төрлийн арьс ширний үсний уг нь бүрэн гүйцэд авагдсан, өнгөн ба шар махан тал нь цэвэр толигор, нугалаасгүй, толбогүй, нэвт идээлэгдэж будагдсан жигд өнгөтэй байна.
- ◆ Анхан шатны боловсруулалт хийсэн арьс ширний чанарын үзүүлэлт хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

Ангилал	Чанарын үзүүлэлт					
	pH	Татах цэг, °C, (багагүй)	Чийг, %, (ихгүй)	Хромын исэл, %	Өнгө	Тос, %, (багагүй)
Гандсан арьс, шир	2.2-2.6	-	-	-	Цайвар	-
Вет блю	3.5-4.2	95.0	65.0	3.0-6.0	Жигд хөх цэнхэр	-
Вет вайт	-	60.0	65.0	-	Цагаан цайвар	-
Краст	3.5-4.5	-	14.0	3.0-6.0	Жигд	4.5

- ◆ Арьс ширэнд идээлэг хийхдээ хромын 6 валенттай давс хэрэглэхийг хориглоно.

### 3.1.3 Шийдвэрлэх арга хэмжээ

Арьс ширний салбарт тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх дараах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Арьс ширний салбар мэргэжлийн боловсон хүчний дутагдалд орох өндөр эрсдэлтэй байна. Иймд тус салбарыг сурталчлах, үйлдвэрлэл эрхлэгчид болон суралцагчдын хоорондын уялдаа холбоог сайжруулж үйлдвэрлэгчдэд шаардлагатай боловсон хүчнийг их, дээд сургуулиудад бодлоготой бэлтгэдэг тогтолцоог дэмжих,
- Малын эрүүл ахуйг сайжруулах, эрүүлжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийн хяналт, мониторингийг сайжруулж төслийн санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх,

- Мал, аж ахуйн түүхий эдийн арчилгаа, тордолтын анхан шатны цэгүүдийг олноор байгуулах, логистикийн боловсронгуй сүлжээг бий болгох,
- Түүхий эд бэлтгэлийн чанарт суурилсан үнийн тогтолцоог бий болгохын тулд хөдөө аж ахуйн биржийн арилжааг чанарт суурилсан үнийн системээр явуулах,
- Үйлдвэрлэл эрхлэгчид, хэрэглэгчдэд мэргэжлийн яам, агентлагуудаас сургалт, сонсгол явуулж олон нийтийн боловсролыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

### 3.2 Ноос, ноолуур боловсруулах салбар

#### 3.2.1 Ноос, ноолуур боловсруулах салбарын өнөөгийн байдал

Монгол улсад ноолуурын салбарт нийт 131, ноосны 257 аж ахуй нэгж байгууллагууд 9000 гаруй ажиллагсадтай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд түүхий ноолуур бэлтгэлээрээ манай улс дэлхийд БНХАУ-ын дараа 2 дугаарт орж байна.

#### Хүснэгт 16. Ноос, ноолуурын салбарын нөхцөл байдал

Үзүүлэлт	Ноолуурын салбар	Ноосны салбар
Түүхий эдийн нөөц (жилд) 2014 оны байдлаар	- Ямааны ноолуур - 7000 тонн	- Хонины ноос - 23000 тн - Тэмээний ноос - 1100 тн - Сарлагийн хөөвөр - 200 тн
Салбарын үйлдвэрүүдийн нийт хүчин чадал (жилд)	- Ээрмэл - 1400 тн - Сүлжмэл бүтээгдэхүүн - 2.8 сая.ш - Нэхмэл - 450 мян.м	- Ээрмэл - 2500 тн - Хивс - 1.8 сая.м <sup>2</sup> - Эсгий - 1 сая.м - Нэхмэл - 500 мян.м
1. Борлуулалт 2. Экспорт	1. 560-600 тэрбум төгрөг 2. 260-290 сая.ам.дол	1. 50 тэрбум.төг 2. 15 сая.ам.долл

2012 онд ноос, ноолуурын боловсруулах үйлдвэрүүд нийт түүхий эдийнхээ 30%-ийг гүн боловсруулж, 60%-д анхан шатны боловсруулалт хийж нийт 264 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2010 онтой харьцуулахад 20%-иар өссөн үзүүлэлттэй байна.

#### Хүснэгт 17. Монгол Улсын бусад улсуудтай хийж буй ноос, ноолуурын бүлгийн бүтээгдэхүүний гадаад худалдаа<sup>9</sup>, мян.ам.доллар


Улс	2010		2011		2012		2013		2014	
	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт
БНСУ	621	226	816	0	1,246	83	1,194	307	302	259
БНХАУ	147,239	1,065	154,273	1,552	170,380	1,262	198,968	1,537	250,230	1,688
Итали	24,048	173	39,593	14	25,935	66	42,331	41	40,711	12
Орос	522	175	732	193	539	116	424	58	512	19
Бусад	18,547	1,172	16,121	535	8,032	1,343	16,676	426	19,426	655
<b>Нийт</b>	<b>190,977</b>	<b>2,811</b>	<b>211,535</b>	<b>2,295</b>	<b>206,132</b>	<b>2,870</b>	<b>259,593</b>	<b>2,370</b>	<b>311,181</b>	<b>2,633</b>

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

<sup>9</sup> БТКУС-ийн 8 орны кодоор 51-ээр эхэлсэн бүх барааны нийлбэр дүн.


Уг салбарт дотооддоо ээрэх, сүлжих, нэхэх үйлдвэрлэл буюу эцсийн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадал муу байдгаас хувцас, сүлжмэл эдлэл үйлдвэрлэхэд хэрэглэгдэх утас болон давууны дийлэнх хэсгийг импортоор хангадаг бөгөөд сүүлийн 3 жилд дунджаар 214 сая ам.долларын утас, давуун бүтээгдэхүүн импортлосон байна. Харин дотоодын нийт түүхий эдийн зөвхөн 25-35%-ийг ээрмэл утасны үйлдвэрлэлд ашиглаж байна.

Дүрслэл 6. Түүхий эд бэлтгэл



Эх сурвалж: Аж үйлдвэрийн яам

Дүрслэл 7. Тоног төхөөрөмжийн хүчин чадал



Эх сурвалж: Аж үйлдвэрийн яам

Монгол Улсын дотоод зах зээлийн багтаамж бага хэдий ч өнөөдрийн байдлаар ноолуурын салбарын нийт бүтээгдэхүүний 60 орчим хувь нь дотоодод борлогддог ба энэ нь Япон, ОХУ-аас Монгол Улсад ирж буй жуулчид их хэмжээгээр худалдаж авдагтай холбоотой.

Хүснэгт 18. Түүхий эдийн ашиглалтын түвшин

Үзүүлэлт	Ноолуурын салбар	Ноосны салбар
Ашиглалтын хувь хэмжээ	<ul style="list-style-type: none"> <li>13.1-15.0%-иар бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.</li> <li>65-68%-ийг угаасан хэлбэрээр экспортолдог.</li> <li>15-19%-ийг самнасан байдлаар экспортолдог.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>70%-ийг бэлэн бүтээгдэхүүн</li> <li>30%-ийг нь угаасан хэлбэрээр экспортолдог.</li> </ul>

Ноолууран бүтээгдэхүүнүүд нь гадны зах зээл дээр эрэлт ихтэй байдаг ч экспортын 85%-ийг түүхий ноолуур эзэлж байна. 2014 онд ноос, ноолуурын экспортын орлого 311.2 сая ам.доллар буюу нь нийт экспортын 5%-ийг эзэлж байна.

**Хүснэгт 19. Дэлхийн улс орнуудын Азийн улсуудтай хийсэн ноос, ноолуурын бүлгийн бүтээгдэхүүний гадаад худалдаа, мян.ам.доллар**


Улс	2010		2011		2012		2013	
	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт
БНСУ	65,146	236,407	93,629	312,222	82,273	211,218	70,742	201,736
БНХАУ	1,526,314	512,327	1,705,188	586,776	1 617,697	567,509	1,644,638	560,085
Итали	669,702	496,206	836,249	688,956	781,884	512,267	762,882	517,211
Орос	12,092	11,999	10,001	17,125	8,536	33,205	14,075	14,047
<b>Нийт</b>	<b>2,273,254</b>	<b>1,256,939</b>	<b>2,645,067</b>	<b>1,605,079</b>	<b>2,490,390</b>	<b>1,324,199</b>	<b>2,492,337</b>	<b>1,293,079</b>

Эх сурвалж: [www.trademap.org](http://www.trademap.org)


Санхүүжилтийн хомсдлоос шалтгаалан гадаад зах зээл дээр зар сурталчилгааг хангалттай явуулж чадахгүй байгаагаас Монгол Улсын ноолууран бүтээгдэхүүн гадаадын худалдан авагчдад танил болж чадахгүй байна.

Түүнчлэн хамтын маркетингийн давуу талыг Монгол Улсын үйлдвэрлэгчид ойлгоогүйгээс тус тусдаа бүтээгдэхүүнээ борлуулж, гадаад зах зээл дээр дорвитой үр дүнд хүрэхгүй байна. Иймд, нэгдсэн маркетингийг гадаад зах зээлд хийх, хамтын бренд тэмдэг бий болгох зорилгоор “Монголын ХААН ширхэгт” чанарын гэрчлэх тэмдгийг Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил” төслийн дэмжлэгтэйгээр бий болгож, ҮХААЯ-ны нэр дээр 2013 онд, 2014 онд гадаадын 34 оронд бүртгүүлээд байна.

**Дүрслэл 8. Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл**




**Дүрслэл 9. Нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл**



Эх сурвалж: Аж үйлдвэрийн яам

Дүрслэл 10. Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл



Эх сурвалж: Аж үйлдвэрийн яам

Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

- “Монголын ХААН ширхэгт”-ийн гэрчлэх тэмдгийг олон улсын байгууллагад бүртгүүлж, баталгаажуулах. Энэ хүрээнд Европын Холбоо, Их Британи, Япон, АНУ, Австрали, ОХУ, БНХАУ зэрэг 40 гаруй улсад хүсэлт гаргасны дагуу 34 улсад бүртгэгдээд байна.
- Монголын Хаан Ширхэгтийг гэрчлэх тэмдгээр бүртгүүлэх нь Монголыг онцгой чанартай, шинжлэгдсэн, олон улсад итгэмжлэгдэж баталгаажсан ноолууран бүтээгдэхүүний нийлүүлэгч гэдгээр нь олон улсын зах зээлд нэр хүндтэй болгох чухал алхам юм.
- Үзэсгэлэн худалдаа, олон улсын зах зээлд Монгол Улсын бренд, компаниуд танигдаагүй байдаг тул Лондон, Флоренс, Парис, Берлин, Нью-Йорк, Хонг-Конг, Токиод болох томоохон үзэсгэлэнгүүдэд оролцож, таниулах ажлыг зохион байгуулж эхлээд байна.
- Нэхмэлийн хүрээлэнгийн ноос, ноолуурын сорилын төвийн лабораторид IWTO (International Wool Trade Organization)-ийн лабораторийн лиценз авахаар эхний сорилуудын дүнг явуулаад байна.
- Ноос, ноолуурын сорилын баталгаажуулалтын лабораторийн чадавхийг сайжруулахад улсын төсөвт тодорхой хөрөнгө төсөвлөн шаардлагатай



тоног төхөөрөмж авахад дэмжлэг үзүүлж байна.

### 3.2.2 Ноос, ноолуур боловсруулах салбарын хүндрэлтэй асуудлууд

Ноос, ноолуур боловсруулах салбарт тулгарч буй гол асуудал нь түүхийгээр экспортлож буй явдал юм. 2012 оны байдлаар нийт бэлтгэсэн ноолуурын 63%-ийг угааж боловсруулсны дараа экспортод гаргаж, 18%-ийг ээрмэлийн үйлдвэрлэлд ашиглаж байна. Харин ноосны хувьд түүхий эдийн 80%-ийг дотооддоо боловсруулж байгаа боловч даавууны үйлдвэрлэл хөгжөөгүй, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй байна.



Цаашилбал (i) угаасан ноос, ноолуурын экспортын татвар байхгүйгээс анхан шатны боловсруулалтаас экспортлоход хамгаалалт байхгүй, (ii) үйлдвэрүүд эргэлтийн хөрөнгийн дутагдалтай байдгаас дотоодын үйлдвэрлэгчид түүхий эдээ худалдаж авах санхүүгийн боломж бага, (ii) суурилагдсан тоног төхөөрөмжийн хүчин чадал дутуу, ялангуяа ээрэх, сүлжих шатны үйлдвэрүүд техник, тоног төхөөрөмжөөр дутмаг, (iii) мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай байдаг, (iv) эцсийн шатанд үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар тааруу, гадаадад борлуулах тогтолцоо байхгүй байгаа нь уг салбарт хүндрэл үүсгэж байна.


### 3.2.3 Төрөөс баримталж буй бодлого, санхүүжилт

Төрөөс ноос, ноолуур боловсруулах салбарт дараах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

- **Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх (НҮДЭН) арга хэмжээ (МБ, ХХААЯ, СЯ):** Богино хугацаанд самнасан ноолуурын үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, үйлдвэрүүдийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажлын байрыг хадгалах, дунд хугацаанд хөдлөх хөрөнгийг барьцаалж, ноолуурын түүхий эдийн агуулахын үлдэгдлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ бүтээгдэхүүн бий болгох, үндэсний үйлдвэрүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх, үйлдвэрлэлийг өргөтгөх зорилгоор Монголбанкнаас 30 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, эргэн төлөлт бүрэн хийгдсэн.
- **Ноолуурын салбарын экспортыг дэмжих төсөл:** Ноолуур боловсруулах үндэсний 12 компани нэгдэн “Монгол ноолуур нэгдэл”-ийг байгуулж хөрөнгөө нэгтгэн худалдааны нэгдсэн сүлжээ бий болгож “Mongolian noble fibre” бренд нэрээр гадаадад бүтээгдэхүүн гаргах, нэгдсэн маркетинг хэрэгжүүлэх, бэлтгэгдсэн түүхий эдийг 100% дотооддоо боловсруулж Итали, БНХАУ-ын үйлдвэрлэгчидтэй “ЭКО” бүтээгдэхүүний үйлдвэрлэлтээр өрсөлдөх, хамгийн сүүлийн үеийн автомат тоног төхөөрөмжтэй үйлдвэрлэлд нэвтрэх чиглэлээр ажиллаж байна. Тус төсөлд эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд нийт 142 тэрбумын төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Дахин 180 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж үзсэн байна.
- **Импортыг орлуулах “Монгол ноосон даавуу төсөл”:** Угаах боловсруулалт хийсний дараа экспортолж байгаа ноосыг дотооддоо гүн боловсруулж, хялгасыг ялган авч ноолуурлаг ширхэгээр нь даавуу үйлдвэрлэх, хаягдал хялгасыг барилгын дулаалгын материал үйлдвэрлэх төсөл. Мөн энэ төслийн хүрээнд сурагчийн болон төрийн албан хаагчдын дүрэмт хувцас болон өргөн хэрэглээний хувцасны зориулалттай цэвэр болон холиотой даавуу үйлдвэрлэж оёдлын салбарт нийлүүлэх зорилготой. Санхүүжилтийн хувьд эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж шинэчлэхэд зориулж 75 орчим тэрбум төгрөгийг олгосон. Цаашилбал, үндэсний үйлдвэрүүдэд ноос тушаасан малчдад 33 тэрбум төгрөгийн татаас олгосон байна. Эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэд дахин 40 тэрбум төгрөг шаардлагатай гэж үзсэн байна.

Тус салбарт 2011-2014 онд Засгийн газрын бонд, Чингис бонд, Монголбанкны эргэлтийн хөрөнгийн санхүүжилт зэрэг хэлбэрээр 285.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байдаг.

### Дүрслэл 11. Ноолуурын салбарын үйлдвэрүүдийн зээлд хамрагдсан байдал



Эх сурвалж: Аж үйлдвэрийн яам

### Дүрслэл 12. Ноосны салбарын үйлдвэрүүдийн зээлд хамрагдсан байдал



Эх сурвалж: Аж үйлдвэрийн яам

Ноолуурын салбар нь ирээдүйд Европын холбооны улсууд, БНХАУ, ОХУ, Япон, Солонгос зэрэг улсууд руу экспортоо нэмэгдүүлэх боломжтой буюу эдгээр улсууд нь уг салбарын зорилтот зах зээл юм. Европын холбооны улсуудын хувьд (i) чийглэг, сэрүүн уур амьсгал, (ii) хэрэглэгчид нь тансаг бүтээгдэхүүн их хэмжээгээр хэрэглэдэг, (iii) “Home textile” төрлийн бүтээгдэхүүнд ноолуур ашиглах сонирхол их, (iv) байгалийн гаралтай бүтээгдэхүүний эрэлт ихэсч байгаа зэрэг нь манай улсын хувьд давуу тал болохоор байна. Харин БНХАУ нь ноолууран бүтээгдэхүүнээ экспортлох бус илүү дотооддоо өндөр үнээр борлуулах сонирхолтой болсон тул энэ нь зах зээлд нэмэлт орон зайг бий болгож байна.

#### 3.2.4 Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замууд

Ноос, ноолуур боловсруулах салбарын давуу болон сул тал, тулгамдсан асуудал, цаашдын боломжуудыг SWOT шинжилгээгээр тодорхойлж Хавсралт 5 ба Хавсралт 6-д харуулав.

Чанарын хувьд БНХАУ-тай харьцуулахад Монгол Улсын ноолуур өрсөлдөх чадвар харьцангуй сул буюу илүү өргөн голчтой байдаг. Энэ нь боловсруулалтын анхан шат буюу түүхий эд бэлтгэлийн муу байдагтай холбоотой. Тиймээс Монгол Улсын ноолуурын өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд чанарт суурилсан үнийн тогтолцоог бий болгох асуудал чухал нөлөөтэй юм. Үүний тулд Хөдөө аж ахуйн биржийг дараах байдлаар ашиглах нь үр дүнтэй гэж үздэг.

- Ноолуур боловсруулах үйлдвэрүүд ямар бүтээгдэхүүн авах хүсэлтэй байгаагаа биржид ирүүлэх.
- Үйлдвэрүүдээс ирүүлсэн захиалгыг ХАА-н биржээс чанар, шаардлагын дагуу бэлтгэж өгдөг байх. Тодруулбал, малчдаас ирсэн түүхий ноолуурыг

ХАА-н бирж урт, өргөн, өнгө гэх мэт чанарын ангиллаар ялгаж, нөөцөлдөг байх нь чухал юм.

- Түүнчлэн ХАА-н бирж малчдаас авах түүхий ноолуурандаа хатуу шаардлага тавьж, цэвэрхэн бэлтгэсэн ноолууранд тухайн чанарт нь тохирсон харьцангуй өндөр үнийг санал болгодог байх.

Түүхий эд бэлтгэлээс гадна ноос, ноолуурын өрсөлдөх чадвар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд тоног төхөөрөмжийн шинэчлэл чухал үүрэгтэй. Аж үйлдвэрийн яамнаас гаргасан тооцоогоор ноолуурын салбарт (i) түүхий эд бэлтгэл, (ii) тоног төхөөрөмжийн шинэчлэлийн зардалд нийт 850 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалт шаардлагатай гэж үзсэн байдаг. Уг хөрөнгө оруулалтыг хийснээр дараах үр дүнд хүрэх юм. Үүнд:

- Ноолуурыг 100% дотооддоо боловсруулна.
- Ээрмэл утасны үйлдвэрлэл 4000 тн-д хүрнэ.
- Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6 сая ширхэгт хүрч, үүний 80%-ийг экспортлоно.
- Ноолуурын салбарын нийт үйлдвэрлэл 1.9 их наяд төгрөг хүрнэ.
- 3900 орчим ажиллагсадтай 200 гаруй жижиг сүлжмэлийн болон оёдлын үйлдвэрүүд орон нутагт бий болно.
- Салбарын нийт ажлын байр 25-30 мянгад хүрч, ажиллагсдын сарын дундаж орлого 600,000-700,000 төгрөгт хүрнэ.

## 4. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Энэхүү бүлэгт ХАА-н салбарт төрөөс санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх замаар тус салбарыг амжилттай хөгжүүлсэн улс орнуудын туршлагыг танилцуулах болно.

### 4.1 Канад

Канад улс нь ХАА-н үйлдвэрлэл болон экспортоороо дэлхийн тэргүүлэгч улсуудын нэг юм. Бусад хөгжингүй улсуудтай адилаар ХАА-н салбарын ажиллах хүч болон ДНБ-д оруулах хувь 20-р зууны туршид буурсан боловч ХАА нь чухал салбар хэвээр байна.

Тус улсаас хөдөө аж ахуйн салбарт авч хэрэгжүүлж буй бодлого нь салбарын бүтээмж, чанарыг сайжруулах замаар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор 20 орчим хөтөлбөрийг Засгийн газраас нь авч хэрэгжүүлдэг байна. Хөтөлбөрүүдийг нь нэгтгэн авч үзвэл бүтээгдэхүүнийг тариалахаас эхлээд боловсруулах, борлуулах хүртэл бүх төрлийн дэмжлэгийг засгийн газар нь ХАА-н нөхөрлөлүүд, санхүүжилт, судалгааны байгууллагуудаар дамжуулан газар тариалан, мал аж ахуй эрхлэгчдэд олгодог байна. Хөтөлбөрүүдээс жишээ дурдвал:

- *Урьдчилгаа олгох*: Тариалан эрхлэгчдэд тариа тарих эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн дэмжлэг олгох. Засгийн газраас ХАА-н нөхөрлөлд зориулан баталгаа гаргах бөгөөд нөхөрлөл нь уг баталгааг ашиглан банкнаас хямд хүүгээр зээл авч, тариалан эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгийн санхүүжилт олгодог байна.
- *Газар тариалангийн даатгал*: Тариаланчдын байгалийн хүчин зүйлсээс үүдэлтэй эрсдэлийг хямд өртгөөр даатгуулах. Даатгалын шимтгэлийг холбооны, мужийн болон тариаланчид хуваах замаар өртгийг бууруулдаг байна.
- *ХАА-н зээлийн хууль*: Уг хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас газар тариалан эрхлэгчдэд зориулан зээлийн 95 хүртэлх дүнд баталгаа гарган өгдөг байна. Зээлийн зориулалт нь тариаланчдад шинээр аж ахуй эрхлэх, технологио шинэчлэх, бүтээгдэхүүнээ боловсруулах, түгээх болон борлуулахад чиглэдэг ба журамд заасан шаардлагууд хангагдсан нөхцөлд баталгааг засгийн газраас гаргадаг байна.

Канадын засгийн газраас хөдөө аж ахуйн санхүүжилтийг дэмжих зорилгоор 1959 онд “Farm Credit Canada-FCC” банкыг байгуулсан байна. Уг банк нь хөдөө аж ахуй эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах, түрээслэх, үндсэн хөрөнгө барьж байгуулахад санхүүжилт олгохоос гадна санхүүгийн төлөвлөлт, зах зээлийн судалгаа зэрэг нэмэлт үйлчилгээнүүдийг санал болгодог.

Тус банк нь Канадын Хөдөө, аж ахуйн ямаар дамжуулан үйл ажиллагаагаа Засгийн газарт тайлагнадаг. FCC нь бонд, өрийн бичиг, институциональ зээл, урт хугацааны хөтөлбөрүүдийн эх үүсвэрээр дамжуулан дотоод, гадаадын зах зээлээс үйл ажиллагааны санхүүжилтээ төвлөрүүлдэг. FCC-ийн бүтээгдэхүүний багцад 29 жил хүртэл хугацаатай мал аж ахуй, газар тариалангийн орц, тоног төхөөрөмж, дэд бүтэц зэрэг хэд хэдэн төрлийн зээл багтах ба нийт багцын үнэлгээ нь ойролцоогоор 25 тэрбум ам.доллар байна.

#### 4.2. Бразил

Бразил улс нь ХАА-н салбараа амжилттай төрөлжүүлж чадсан, хүнсний бүтээгдэхүүний хувьд бие даасан улс юм. ХАА-н салбар нь ДНБ-ий ойролцоогоор 8 орчим хувийг бүрдүүлэх ба нийт ажиллагсдын дөрөвний нэг нь ХАА-н салбарт ажиллаж байна.

Газар тариалангийн салбарын хувьд Бразил нь чихрийн нишингэ болон кофений үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлдэг ба кокоа, шош, жүрж, тамхи, самарны цэвэр экспортлогч улс болно. Харин мал аж ахуйн хувьд тахиа, гахай, сүүний аж ахуйгаараа өндөр байр суурь эзэлдэг. ХАА-ын нийт үйлдвэрлэлийн 60%-ийг газар тариалан, үлдсэн 40%-ийг мал аж ахуйн салбар бүрдүүлдэг. Бразилийн нийт экспортын 35% нь ХАА-ын салбарын бүтээгдэхүүн байх ба кофе, шош, үхрийн мах, чихрийн нишингэ, хөлдөөсөн тахианы экспортоороо дэлхийд тэргүүлэгч юм.

ХАА-н салбарын бодлого				
Санхүүжилт		Орон Нутгийн Даатгал	Борлуулалт, Орлогын Баталгаа	Дэд бүтэц
Орон нутгийн зээлийн үндэсний систем	ХАА-н санхүүжилтийн шинэ хэрэгслүүд	ХАА-н салбарын орлого, бүтээмжид голчлон чиглэсэн өргөн хүрээний даатгалын систем.	- Хамгийн бага үнийн баталгаа; - ЗГ-ын худалдан авалт; - Борлуулалтад зориулсан тусгай зээлийн шугам; - Опционы арилжаа; - Арилжааны худалдан авагчдын урамшууллын хөтөлбөр;	<b>Хурдацтай Хөгжлийн Хөтөлбөр</b> Үйлдвэрлэлийн өртөг, бүтээгдэхүүний үнийг бага байхад нөлөөлж, өрсөлдөх чадвар болон орлогыг нэмэгдүүлж байна.
1. Эргэлтийн хөрөнгө ба Борлуулалтад (8.63%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай.) 2. Хөрөнгө Оруулалтад (7.47%-ийн хүүтэй.) 3. Хөтөлбөрүүд (6.75-9.5%-ийн хүүтэй, 6-12 жилийн хугацаатай.)	1. ХАА-н зээлийн өрийн бичиг (Банкаар дамжина.) 2. ХАА-н зээлийн эрхийн сертификат (Банкаар дамжихгүй.) 3. ХАА-н авлагын сертификат (Банкаар дамжихгүй.)	- Цаг агаарын таагүй үзэгдэл; - Мал, амьтны гаралтай өвчин; гэх мэт		

Тус улсын Засгийн газраас хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, чанарыг сайжруулах зорилгоор үйлдвэрлэл, борлуулалт, дэд бүтэц, ААН болон байгаль орчин үүсч болох эрсдэл зэргийг хамарсан олон тооны хөтөлбөрийг авч хэрэгжүүлэн, үндэсний цогц бодлого баримталдаг байна. ХАА-ын салбарт хөгжлийн дараах үндсэн бодлогыг баримталсан.

Хөтөлбөрүүдээс жишээ дурдвал:

- *Орон Нутгийн Зээлийн Үндэсний Систем (Санхүүжилт)*: ЗГ-ын баталгаатайгаар ажиллах хүч, капитал, арилжааны банкны хугацаатай хадгаламж, хөрөнгө оруулалтад зориулсан ХАА-ын салбарын зээлийг бага хүүний түвшинд тусгай хөтөлбөрүүдийн хүрээнд олгосон.
- *ХАА-ын Зээлийн Өрийн Бичиг (Санхүүжилт)*: Арилжааны банк нь ЗГ-ын баталгаатайгаар хөрөнгө оруулагчдад зээлийн өрийн бичиг гаргах замаар ХАА-ын үйлдвэрлэгчдийг эх үүсвэрээр хангадаг байна.
- *Хамгийн Бага Үнийн Баталгаа (Борлуулалт)*: Үйлдвэрлэгчдийн орлогыг дэмжих зорилготой боловч борлуулалт болон санхүүжилтийн эх үүсвэрийн үүргийг давхар гүйцэтгэдэг.

#### 4.3. Шинэ Зеланд

ХАА-н салбар нь Шинэ Зеландын ДНБ-ий 6%-ийг бүрдүүлдэг бол экспортын бүтээгдэхүүний ойролцоогоор гуравны хоёрыг бий болгодог байна. ХАА-ын салбарын үндсэн бүтээгдэхүүн нь сүү, сүүн бүтээгдэхүүн, хонины мах болон ноос, үхрийн мах, цэцэрлэгийн аж ахуй юм.

1960-аад оны дунд үеийг хүртэл Шинэ Зеландын Засгийн газар ХАА-ын салбартаа бага хэмжээний дэмжлэг үзүүлдэг байв. Гэвч дараалсан төлбөрийн тэнцлийн хямралуудаас шалтгаалан Засгийн газар үйлдвэржилт болон гадаад валютын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор өргөн хүрээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Тухайлбал:


- Татаас, зээл (1930 онд анх олгосон);
- Бэлчээрийн газрын хөгжил болон нөөцийг дэмжсэн тэтгэмж (1970-аад оны дунд үеэс эхэлсэн);
- Бордоо, хогийн ургамалыг устгах, усжуулалтын системийг дэмжсэн татаас (1965-75 оны хооронд);
- Тариланчдад зориулсан төрөл бүрийн татварын хөнгөлөлт (1960-70-аад оны хооронд);
- Уламжлалт газар тариалангийн экспортын төрөлжилтийг урамшуулах зорилгоор экспортын хөшүүргийн системийг бий болгосон (1963 онд).

1980 онд Засгийн газрын ХАА-ын салбарт олгосон дэмжлэг нийт гарцын 7% байсан бол 1984 онд энэ хэмжээ 39% хүртэл өссөн бөгөөд үүний гуравны хоёр нь үнийн болон тогтвортой байдлын дэмжлэгүүд байлаа. Харин эсрэгээрээ нийт тусламж, дэмжлэгийн зөвхөн 2.5% нь бордооны татаас байв.

1980-аад онд Шинэ Зеландын Засгийн газраас ХАА-ын салбарт олгож байсан татаас, татварын хөнгөлөлт болон үнийн дэмжлэгийг зогсоож, зах зээлийн


зарчимд шилжүүлсэн. Энэхүү шинэчлэлийг Шинэ Зеландын Төв банк удирдан, зохион байгуулсан ба уг бодлого хэрэгжсэнээр цөөнгүй тооны ААН үйл ажиллагаа зогсоход хүрсэн юм. Гэвч шинэчлэлийн үр дүнд Шинэ Зеландын ХАА-ын салбарын үйлдвэрлэл тогтвортой нэмэгдэж, дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар сайтай байна.

**Дүрслэл 13. Шинэ Зеландын ХАА-ын салбарын дэмжлэг**



Эх сурвалж: OECD

**Дүрслэл 14. Шинэ Зеландын ХАА-ын салбарын үйлдвэрлэл**



Эх сурвалж: FAOSTAT

Шинэчлэлийн бодлогыг ерөнхийд нь дүгнэвэл:

- 1986-1988 оноос өмнө ХАА-ын үйлдвэрлэл, худалдааны хувьд хэрэгжүүлж байсан бодлогын маш бага хэсгийг өнөөдөр баримталсан хэвээр бөгөөд ХАА-ын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дэмжлэгээрээ OECD-ийн орнуудын дунд хамгийн багад тооцогдож байна. Дотоодын үнийн түвшин нь дэлхийн зах зээлийн үнийн түвшинтэй бүрэн уялдаатай ба зөвхөн мал, амьтны гаралтай өвчнийг хянах болон байгаль, цаг уурын таагүй нөхцөл байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас оролцож байна.
- Бараг бүх секторыг төрийн зохицуулалтаас чөлөөлсөн бөгөөд сүү, сүүн бүтээгдэхүүний экспортлогчдод тавьсан бүх хязгаарлалтыг 2010 оны эцэс гэхэд арилгасан байна. Зесфри хэмээх компани нь Австралиас бусад улс руу Шинэ Зеландад үйлдвэрлэсэн киви жимс шууд экспортлох бүрэн эрхтэй цорын ганц байгууллага юм. Бусад компаниудын хувьд тус байгууллагаар дамжуулан эсвэл өөрсдөө бие даан экспорт хийх боломжтой.

#### 4.4 БНХАУ

##### а) БНХАУ-ын гадаад худалдааны хурдацтай өсөлт

БНХАУ-ын гадаад худалдааны шинэчлэл 1979 оноос эхэлсэн. Импортыг орлох аж үйлдвэрийн бодлогоос татгалзаж экспортод чиглэсэн өсөлтийн бодлого хэрэгжүүлж эхэлсэнээр БНХАУ-ын худалдаанд хурдацтай өсөлт бий болжээ. 1978



онд 20.6 тэрбум ам.доллар байсан гадаад худалдааны эргэлт 2009 он гэхэд 2207.2 тэрбум ам.доллар болж 31 жилийн туршид 106 дахин өсч, гадаад худалдаагаар дэлхийд 32-т жагсаж байсан бол хамгийн том экспортлогч орон болж хөгжсөн юм. Үүгээрээ АНУ, ХБНГУ, Японы түүхийг давтсан билээ.<sup>10</sup>

1979 оноос хэрэгжүүлж эхэлсэн бодлогын хүрээнд хөдөлмөр түлхүү ашиглагддаг салбарууддаа экспортод чиглэсэн стратеги баримталсан. Харин капитал болон технологи түлхүү ашиглагддаг салбарууддаа импортыг орлох бодлого үргэлжлүүлэн баримталсаар байв. БНХАУ-ын гол бодлого нь:

1. Экспортод чиглэсэн гадаадын хөрөнгө оруулагчдыг татах,
2. Экспортыг урамшуулсан бодлого.

### **1. Экспортод чиглэсэн гадаадын хөрөнгө оруулагчдыг татах бодлого:**

- **Эдийн засгийн тусгай болон бусад онцгой үүрэг бүхий бүсүүдийг байгуулах:** Нэгдүгээрт, БНХАУ нь гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй болсноор 1980 оноос эхлэн эдийн засгийн чөлөөт бүсийг Shenzhen, Zhuhai, Shantou, Xiamen зэрэг газруудад байгуулж гадаадын хөрөнгө оруулагчдыг татсан юм. Тодруулбал:
  - Дэд бүтцийг хөгжүүлсэн.
  - Гадаадын хөрөнгө оруулагчдын импортын тоног төхөөрөмжийн тарифийг чөлөөлж, компанийн орлогын татварыг бууруулах, чөлөөлөх зэрэг татварын бодлого хэрэгжүүлсэн.
  - Гадаадын хөрөнгө оруулалт бүхий төслийг тодорхойлж, экспортод чиглэсэн төслийг урамшуулах арга хэмжээ авсан (Нийт гарцын 70-аас илүүг экспортод чиглэсэн бол компанийн орлогын татварын 50%-ийг чөлөөлөх).

Дээрх бодлогын хүрээнд 1984 онд тус улс нь далайн эргийн 14 хотод эдийн засаг ба технологийн хөгжлийн бүсүүдийг бий болгож ижил төрлийн бодлогыг хэрэгжүүлж байсан. Улмаар шинэ, дэвшилтэт технологи бүхий аж үйлдвэрийн хөгжлийн бүс, экспорт боловсруулалтын бүс зэрэг тусгай үүрэг бүхий бүсүүдийг байгуулсан. Ийнхүү гадаадын хөрөнгө оруулагчдыг татсанаар харьцангуй хямд газар, хөдөлмөр болон гадаадын технологи, менежементийг нэгтгэж чадсан юм. Тэдгээр тусгай бүсүүд нь одоогоор БНХАУ-ын гадаад худалдааны хөгжлийн тулгуур болоод байна.

<sup>10</sup> 1874-1970 оны хооронд буюу 100 орчим жилийн хугацаанд АНУ-ын худалдааны тэнцэл нь хэд дахин өссөн. Мөн Герман улс нь 1952-2005 оны хооронд буюу 54 жилийн туршид худалдааны тэнцэл нь хэдэн арав дахин өссөн бол Японы хувьд 1981 оноос хойш гадаад худалдааны тэнцэл нь сайн байв. W.Zixian ба Y.Zhengwei, 2006, “Reasons of Formation, Evolution Trend of and Countermeasures for China’s Favorable Balance of Foreign Trade”-ийг харна уу.

## **2. Экспортыг урамшуулсан бодлого**

*Экспортын татварыг хөнгөлөх бодлого:* ДХБ-ийн дүрэм ёсоор, экспортын бүтээгдэхүүнүүд нь гадаад зах зээлд гарахдаа шууд бус татвараас чөлөөлөгдсөн байдаг. БНХАУ нь 1985 онд экспортын шууд бус татварыг хөнгөлөх бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Тус бодлого нь экспортлогч үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний татварыг буцаан олгосноор хэрэгжиж эхэлсэн. 1994 оны татварын системийн шинэчлэлийн дараа, бүтээгдэхүүний татварыг НӨАТ болон онцгой албан татвараар орлуулсан. Улмаар БНХАУ-ын экспортлогч нарыг бусад орнуудын өрсөлдөгчидтэй хүч тэнцүү өрсөлдөх үндсэн нөхцөлийг бүрдүүлж байсан. Гэвч экспорт маш хурдацтай өссөн нь төсөвт дарамт үүсгэж байсан тул татварын буцаан олголтын хувийг бууруулахаар шийдвэрлэжээ.

*Экспортын урамшуулал ба худалдааны хөнгөлөлт:* БНХАУ нь экспортыг дэмжих бодлогыг тууштай хэрэгжүүлсээр ирсэн. Одоогоор тус улс нь 10 гаруй экспортын чөлөөт бүстэй болсон байна. Эдгээрээс Гуанжоугийн чөлөөт бүс нь дэлхийд хамгийн томд тооцогддог. БНХАУ-лс нь ДХБ-д нэгдсэний дараа бодлогоо улам бүр эрчимжүүлж, гаалийн бүрдүүлэлтийн процессийг хялбаршуулсанаар хөрөнгө оруулалтыг илүү татах болжээ. Тодруулбал, Шанхай чөлөөт бүсд гаалийн электрон бүрдүүлэлтийг хийдэг бөгөөд энэхүү систем нь бусад бүсүүдэд ч нэвтэрсээр байна.

### **б) БНХАУ-ын цаашдын хөгжлийн гарц**

Өнгөрсөн 32 жилийн хугацаанд БНХАУ-ын гадаад худалдааны эргэлт 10%-иар тогтмол өсч, өдгөө дэлхийн хамгийн том экспортлогч орон болохын зэрэгцээ дэлхийн хоёр дахь том эдийн засаг болоод байна. Харин хүрээлэн буй орчины асуудал, нийгмийн хөгжил, хот хөдөөгийн ялгаа, баян хоосны ялгаа нь тус орны ирээдүйн хөгжилд тулгамдаж буй асуудал болоод байна. Иймд БНХАУ нь оновчтой худалдааны бодлогоор дамжуулан эдгээр асуудлыг шийдэх гарцыг тодорхойлжээ. Тогтвортой худалдааны бодлогыг эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн тогтвортой байдал, хүрээлэн буй орчны тогтвортой байдал гэж үндсэн гурван тулгуур баганыг тодорхойлсон.

### **Эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгохын тулд:**

- ◆ Инновациар хийгдсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх,
- ◆ Экспортын бүтээгдэхүүний нэмүү өртөг шингэж буй холбоог уртасгах,
- ◆ Үйлчилгээний салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ба үйлчилгээний салбар дахь худалдааг хөгжүүлэх,
- ◆ БНХАУ-ын оюуны өмчийн эрхийн эзэмшлийг өсгөх, дэлхийн хэмжээний

брендийг өсгөх, үндэсний компаниудыг ашиглан маркетингийн сүлжээг хөгжүүлэх,

- ◆ Бүс нутгийн болон олон талт системд гадаад хүрээлэн буй орчныг сайжруулах зорилгоор идэвхтэй оролцох.

**Нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд:**

- ◆ Хөдөлмөр түлхүү оролцдог экспортын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх,
- ◆ Экспортын салбарын бүтээмжийг өсгөх,
- ◆ Хөдөлмөрийн эрхийн хамгаалалтыг сайжруулах,
- ◆ Экспортын салбарын үйлдвэрлэлийн үнэ цэнийн гинжийг өргөтгөх,
- ◆ Дотоодын аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.

**Энергийн хэрэглээг бууруулах, нөөцийн хэрэглээг багасгаж хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд:**

- ◆ Аж үйлдвэрийн салбаруудын бүрдэлтийг тохируулах: бага энерги зарцуулдаг, хүрээлэн буй орчинд ээлтэй салбарууд,
- ◆ Технологийн шинэчлэл хийх: бага энерги, материал хэрэглэдэг,
- ◆ Менежментийн ур чадварыг сайжруулах,
- ◆ Хуул эрх зүйн орчин, бодлогыг боловсронгуй болгох,
- ◆ Хүрээлэн буй орчинд ээлтэй соёлыг бий болгох,
- ◆ Төрийн бус болон хэрэглэгчдийн үүргийг нэмэгдүүлэх.

**Аж үйлдвэрийн салбарыг шинэтгэх:** Гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар шинэ технологийг БНХАУ-д оруулж, түүний дам нөлөөгөөр дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлж, дэлхий дахинд техникийн инноваци хийх, оюуны өмчийн эрх бүхий бүтээгдэхүүнүүдээр экспортоо өсгөх, дэмжих.

**Экспортын бүтээгдэхүүний үнэ цэнийн гинжийг уртасгах:** Одоогоор БНХАУ-ын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөдөлмөр түлхүү ашигладаг. Харин үйлчилгээний салбарт маш бага нэмүү өртөг шингээдэг байна. Тус улсын экспортын бүтээгдэхүүний үнэ тээвэрлэлтийн үнээсээ төдийлөн өндөр биш байдаг. Экспортын бүтээгдэхүүний үйлчилгээний үнэ цэнийн гинжийг уртасгахын тулд:

- ◆ Хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж, БНХАУ-д үндэстэн дамнасан корпорациудын бүс нутгийн төв байруудыг байгуулах,
- ◆ Үйлчилгээний салбарыг нээх, чанарыг сайжруулах,
- ◆ Дотоодын үйлдвэрээс дэлхийн брэндийг бий болгох.

**Үйлчилгээний секторын өрсөлдөх чадварыг сайжруулах:**

- ◆ Хууль эрх зүй, бодлогын таатай орчныг бүрдүүлж үйлчилгээний салбарыг хөгжүүлэх,
- ◆ Үйлчилгээний салбарыг гадаад зах зээлд нээж, менежментийн туршлага хуримтлуулах,
- ◆ Далайн үйлчилгээнээс бий болж буй боломжийг ашиглах.

**Гадаад худалдааны бараа бүтээгдэхүүний бүтцийг сайжруулах:** Нэгдүгээрт, энерги их хэрэглэдэг, их хэмжээний хорт бодис ялгаруулах, эсвэл нөөцөд тулгуурласан экспортын бүтээгдэхүүний экспортыг бууруулах. Хоёрдугаарт:

- ◆ Энергийн эх үүсвэр, нөөцийн гадаадаас нийлүүлэх гарцыг баталгаажуулах,
- ◆ Энергийн эх үүсвэр ба нөөцийн хөгжилд хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
- ◆ Эдийн засаг, худалдаа, улс төр, дипломат харилцааг хөгжүүлэх, бусад улсуудын энергийн эх үүсвэр, нөөцийн экспортыг нэмэгдүүлэх,
- ◆ Тэдгээр улсуудтай энергийн эх үүсвэртэй холбоотой урт хугацааны гэрээ байгуулах,
- ◆ Зах зээлийн үнийн хэлбэлзлээс үүсэх нөлөөллийг бууруулах,
- ◆ Найдвартай олон улсын тээврийн сувгийг байгуулах

Гуравдугаарт, дэвшилтэт технологи болон техникийн импортыг нэмэгдүүлэх, энерги болон нөөцийн хэрэглээний үр ашгийг өсгөх. Дөрөвдүгээрт, байгальд мэдрэмтгий бүтээгдэхүүний импортыг хатуу хориглох, мөн байгальд ээлгүй энэ төрлийн хэрэглээний бүтээгдэхүүнүүдийн импортыг хориглох (Long, 2010).

## 5. ДҮГНЭЛТ, САНАЛ

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбараас хамаарах хамаарал нэмэгдсээр байна. Уул уурхайн баялаг нь нөхөн сэргээгдэхгүй, олборлолтын үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнэ өндөр хэлбэлзэлтэйн улмаас тус салбарт тодорхой бус байдал их үүсч байна. Гэтэл өндөр эрсдэлтэй тус салбараас Монгол Улсын эдийн засаг улам бүр хамааралтай болж байгаа нь манай улсын эдийн засгийн бүтцийг эмзэг болгож байна. Монгол Улсын хэмжээнд уул уурхайгаас бусад салбарын нөөц бололцоо, үйлдвэрлэлийн хүчин чадлыг судлан үзэхэд мал аж ахуйн салбар, түүний дотор ноос, ноолуур, арьс ширний салбар нь тэргүүлэх чиглэлд хөгжүүлэх боломжтой нь харагдлаа. Учир нь дэлхийн бусад орнуудтай харьцуулахад тус салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортын хэмжээгээр бусад салбаруудаас харьцангуй өндөр байдаг бөгөөд харьцангуй давуу талтай байна.

Монгол Улс жилийн 4 улиралтай, эрс тэс уур амьсгалтай байдгаас малын арьс, ширний чанарын голлох үзүүлэлтүүд сайн боловч малын амьдын гэмтэл их, түүхий эд бэлтгэл, арчилгаа тордолгооны анхан шатны цэгүүд байдаггүйгээс чанартай түүхий эд бэлтгэхэд ихээхэн хүндрэл тулгардаг. Түүнчлэн, түүхий эдийн чанарт тулгуурласан үнийн тогтолцоо бүрэлдээгүйгээс шалтгаалан чанартай түүхий эд бэлтгэх, тэдгээрийг ангилах, үнэлэх хөшүүрэг төлөвшөөгүй. Иймд арьс шир, ноос, ноолуурын экспортод анхан шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн голлож байна. Энэ нь тус салбарт логистикийн боловсронгуй тогтолцоо хөгжөөгүй бөгөөд үйлдвэрлэгч, малчдыг холбох зуучлагчид хангалтгүй, зуучлалын дийлэнх хэсэг ченжүүдээр дамжин БНХАУ-д нэмүү өртөг бага шингэн экспортлогддогтой холбоотой.

Мал аж ахуйн салбарт тулгамдаад буй нэн чухал асуудлууд нь мэргэжлийн боловсон хүчний хомсдол, судалгаа шинжилгээний болон мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг байгууллага байхгүй, дотоодын үйлдвэрлэгчдэд түүхий эдийн тасалдал үүсдэг явдал юм. Энэ нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй, борлуулалтын орлого дорвитой нэмэгдэхгүй байгаагийн шалтгаан юм. Улмаар үйлдвэрлэл эрхлэгчдийн гадаад зах зээлд бүтээгдэхүүнээ сурталчилж, олон улсын зах зээлд Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг таниулах боломжийг хязгаарлаж байна.

Мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжсэн, санхүүжилтийн оновчтой арга хэмжээ авсан олон улсын туршлагыг судлан үзэхэд Канад, Бразил, Шинэ-Зеланд, БНХАУ зэрэг улсууд тус салбарт оновчтой бодлого хэрэгжүүлж байжээ.

Дээрх үр дүнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Дотоодын уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр тогтвортой санхүүжилтийн орчинг бий болгох,
2. Мал аж ахуйн салбарт түүхий эд бэлтгэл, тордолт, үйлдвэрлэлийн нэгдсэн логистикийн сүлжээг бий болгох,
3. Арьс шир, ноос ноолуурын салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн эрэлт, шаардлагад нийцэх мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарах, үйлдвэрлэгчид болон боловсролын байгууллагын уялдаа, холбоог сайжруулах,
